БАТЛАВ
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР

УВС АЙМГИЙН БАРУУН БҮСЭД ХӨВ ЦӨӨРӨМ ШИНЭЭР БАЙГУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР (ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ)

2025.03.31 Дугаар 05 Улаанбаатар
хот

1.	Үндэслэл	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.3.10 дахь заалт; Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Монгол улсын 2025 оны Төвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XIII.1.1
2.	Байршил	1. Увс аймгийн Бөхмөрөн сум, Гурван жигэртэй баг, Хужирт хоолой 50° 02' 48.36'' 90° 31' 24.6'' E 2. Увс аймгийн Өмнөговь сум, Баянгол баг;Туулайн тал 49° 03' 31.23'' N 91° 42' 0.56'' E 3. Увс аймгийн Ховд сум, Халиун баг, Голын эхэн 49° 32' 28.92'' N 90° 59' 17.58'' E 4. Увс аймгийн Сагил сум, Өндөр мод баг, Баруун дардай 50° 18' 0.48'' N 91° 41' 53.44'' E 5. Увс аймгийн Давст сум, Хандгайт баг, Улиаст гол 50° 41' 52.73'' N 92° 17' 45.48'' E 6. Увс аймгийн Түргэн сум, Рашаант баг, Хотгор 50° 08' 57.2''N 91° 37' 08.2'' E
3.	Хүчин чадал, зориулалт	1. Батлагдсан зураг төсөвт заасан хүчин чадалтай байх: - Боомтын хярын урт – 20.0 м - ээс багагүй - Хөвийн эзлэхүүн – 20,000.0 м^3 - ээс багагүй - Усны хамгийн их гүн – 1.5 м - ээс багагүй 2. Цөөрмийн тэжээгдэл: - Гол, үер, хур тунадасны ус; 3. Зориулалт: - Бэлчээрийн усан хангамж (ан амьтан, мал); - Газар тариалангийн усалгаа; - Ногоон байгууламж болон модны усалгаа;
4.	Усны барилга, байгууламж барих үе шат, хугацаа	- Тухайн газарт инженер, геологи, ус зүйн судалгаа хийх; - Нэг маягийн зургийн дагуу холболтын зураг хийж захиалагчаар батлуулах; - Усны барилга, байгууламж барих ажил 1 үе шаттай;
5.	Барилгын үндсэн бүтээц, хийцийн шийдэл	- Шороон боомт; - Ус хаях суваг бетон хийцтэй байх; - Хөв цөөрмийн инженер геодези, ус зүйн тооцоо хийх; - Ус гаргуур төсөллөх; - Боомтын хярын өргөн хэсэгт нэмэлт арга хэмжээ төлөвлөх, (явган хүний зам, гүүрэн гарц, хайс хашлага хийх);
6.	Санхүүжилт	Улсын төсөв, Нийт: 603,000,000.0 төгрөг (Зургаан зуун гурван сая)
7.	Тайлан	- Гэрээнд заасан хугацаагаар (2025 оны 11 сарын 01-д багтааж хүлээлгэн өгөх); - Тайланг бичмэл болон цахим, видео хэлбэрээр ирүүлэх; - Холбогдох баримт бичиг, судалгааны материалыг өнгөтөөр *.pdf форматаар 300 dpi нягтралтай скайнердаж cd-нд хавсаргах;

8.	Ажил гүйцэтгэхэд дагаж мөрдөх барилгын норм, дүрэм	<u>Хууль тогтоомжууд:</u> - Монгол Улсын Үндсэн хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Усны тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль - Газрын тухай хууль - Барилгын тухай хууль <u>Норм нормативууд:</u> - Барилгын геодезийн ажил /БНбД 11-08-06/ - Барилга захиалагчийн дүрэм - Барилгын бүтээц ба бууриийн найдваршил. - Ерөнхий шаардлага /БНбД 20-01-11/ - Ачаалал ба үйлчлэл /БНбД 20-04-17/ - Газар хөдлөлтийн бус нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНбД 22-01-01*/ - БНбД 11-07-04 Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг дүрэм - БНбД 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үндсэн журам - БНбД 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж - БНбД 33-04-09 Усны барилга байгууламжийн суурь - БНбД 33-05-09 Усны барилгын ачаалал ба үйлчлэл - БНбД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бутээц - БНбД 33-08-09 Бетон ба төмөр бетон боомт - БНбД 81-33-10 Усны барилгын төсвийн суурь норм - БД 81-105-11 Усны барилга байгууламжийн инженер хайгуул судалгааны ажлын жишиг норм - БД 81-106-11 Усны барилгын зураг төслийн ажлын жишиг үнэ - Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12/ - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; Бусад холбогдох норм, дүрэм, стандартууд
9.	Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	БОУАӨЯ-аас олгодог тусгай зөвшөөрөл: - Усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх, эсвэл, ХББОСЯ-аас олгодог тусгай зөвшөөрөл: - Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэл хийх (БА-2.2). - ЗТ 3.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл
10.	Онцгой нөхцөл	- Газар хөдлөлтөөс үзүүлэх ачаалал, эрсдэлийг тооцсон байх; - Хүн, мал, зэрлэг амьтан осолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх; - Усан сангийн орчимд гоц халдварт өвчинтэй сэг, зэм булшилсан эсэхийг сайтар шалгах;

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР